

Монголын онлайн хэвлэл мэдээллийн залруулгын судалгаа

Д.Идэржаргал

МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн дэд профессор, доктор
(Ph.D), ХМЗ-ийн Ёс зүйн хорооны гишүүн

Монголын онлайн хэвлэл мэдээллийн залруулгын практик

100 залруулгын шинжилгээ

100

залруулгын кейс

82

судалсан ХМБ
/сайт+сошиалд суурьтай
редакц

42

залруулга нийтэлсэн
мэдээллийн сайт

40

залруулга нийтлээгүй
мэдээллийн сайт

Залруулгын кейс цуглуулах, бүртгэх арга

1

Вэбсайтаас хайх

Сайтын дотоод хайлтад “залруулга”, “залруулах нь” түлхүүр үгээр хайх.

2

Google-ийн өргөтгөсөн хайлт

Хуучин архив болон дотоод хайлтаар илрээгүй материалыг Advanced Search, домэйн хязгаарласан хайлтаар олох.

3

Сошиал медиагаас хайх

Тухайн хэвлэлийн албан ёсны сошиал хаягуудаас дээрх түлхүүр үгсээр нэмэлт хайлт хийх.

4

Баримтжуулах

Илэрсэн залруулгын URL холбоосыг хадгалж, нийтлэгдсэн байдлыг screenshot хийж архивлах.

5

Дата ангилалд оруулах

Кейс бүрийг сэдэв, алдааны төрөл, буруутгасан тал, уучлалт, хариу арга хэмжээ, огноо зэрэг хувьсагчаар кодлох.

Тайлбар: “Залруулга олдоогүй” гэдэг нь тухайн редакц залруулга огт нийтэлдэггүй эсвэл алдаа огт гаргадаггүй гэсэн утга биш; дээрх хайлтын аргуудаар кейс илрээгүйг илэрхийлнэ.

Судалгааны хамрах хүрээ

82 мэдээллийн сайтыг хайж шалгаснаас 42-д залруулгын кейс олдов.

82

нийт судалсан

42 (51.2%)

залруулга олдсон


40 (48.8%)

залруулга олдоогүй

100

шинжилсэн кейс

Хамгийн олон залруулгын кейс олдсон хэвлэлүүд



Тайлбар


- “Олдоогүй” гэдэг нь тухайн сайт огт залруулга гаргадаггүй гэсэн дүгнэлт биш.
- Судалгаанд ашигласан түлхүүр үг, архивын хүртээмжээс шалтгаалж илэрц ялгаатай байж болно.
- Хамгийн их залруулга гаргасан нь ёс зүйгүй сайт гэсэн дүгнэлт биш.
- 100 кейс 42 өөр хэвлэл/сайтад тархсан.

Судалсан

ХЭВЛЭЛҮҮД:

zindaa.m	olloo.mn	dorgio.mn	ikon.mn	livetv.mn	news.mn	paparazi.mn	
tsuurhai.mn	zarig.mn	gogo.mn	sonin.mn	tug.mn	ubn.mn	ulguu.mn	unnu.news
zuv.mn	24tsag.mn	control.mn	dursamj.mn	isee.mn	mun.mn	neguun.mn	shuud.mn
tovch.mn	tumen.mn	ulsturch.mn	Монголын мэдээ сонин		arslan.mn	bolod.mn	dens.mn
dnn.mn	eagle.mn	eguur.mn	humanz.mn	polit.mn	reelnews.mn	tac.mn	tsag.mn
unread.today	urug.mn	zogii.mn	Улс төрийн тойм		amlalt.mn	assa.mn	asu.mn
buzznews.mn	elch.mn	erennews.mn	ergelt.mn	fact.mn	gereg.mn	graph.mn	
inews.mn	itoim.mn	ivoice.mn	mass.mn	medee.mn	mgltimes.mn	mining.mn	
miss.mn	mono.mn	murch.mn	newspress.mn	newsroom.mn	newswire.mn	niislel.com	
niislel.mn	niitlel.mn	noorog.mn	peak.mn	posted.mn	record.mn	sergelt.mn	
time.mn	tonshuul.mn	tsahiur.mn	ub.life	unen.mn	unuudur.mn	wego.mn	
word.mn	zaluu.com						

Ямар сэдвийн мэдээлэл залруулгад хамгийн их орсон бэ?



Гол төвлөрөл

Гэмт хэрэг / осол: 39%

Зөрчил: 26%

Улс төр / авлига: 15%

Гэмт хэрэг, осол, зөрчилтэй холбоотой мэдээлэл нийлээд нийт кейсийн 65%-ийг эзэлж байна.

Ямар алдаа залруулга хийхэд хүргэсэн бэ?

Нийт залруулгын 96% нь үнэн бодит байдлыг нягтлах болон нягт нямбай ажиллахтай холбоотой алдаанээс үүдсэн

59

Үнэн бодит байдлыг
нягтлаагүй

38

Нягт нямбай байдал
алдагдсан

18

Нэр андуурсан

14

Зурагтай холбоотой

Үнэн бодит байдлыг нягтлаагүй — 59

Нягт нямбай байдал алдагдсан — 38

Үнэн бодит байдлаас бусад тусдаа алдаа


- хов живийг эх сурвалж болгосон
- ялгаварлан гадуурхсан
- эмзэг мэдээлэл
- шударга ажиллаагүй

Нэр
18

Зураг
14

Бусад: дата, дугаар зэрэг

Алдааны хариуцлагыг хэнд хамаатуулсан бэ?



53%

редакцыг оролцуулан
хариуцлага хүлээсэн

15%

шууд сэтгүүлчээ
буруутгасан

20%

хэнийг буруутгасан нь
тодорхойгүй буюу дийлэнх
тохиолдолд алдаагаа хүлээн
зөвшөөрөхөөс цааргаласан өнгө
аястай

Уучлалт хүсэх практик: Хэнээс уучлалт хүсдэг вэ?

83

уучлалт / хүлцэл хүссэн

17

уучлалт хүсээгүй

5

уншигч / олон нийтээс

83 уучлалт хүссэн залруулгын 78 нь хохирогч талд, харин ердөө 5 нь хүлээн авагч, олон нийтэд хандсан.

→ Залруулгыг олон нийтийн өмнө хүлээх редакцын хариуцлага гэхээс илүү тухайн хохирогчтой холбоотой асуудал мэт авч үзэх хандлага ажиглагдаж байна.

Залруулгаас гадна ямар хариу арга хэмжээ авсан бэ?

15


хариу арга хэмжээний талаар
дурдсан

85

дурдаагүй

7

тодорхой үйлдэл
тэмдэглэлээс танигдсан



Анхаарах зүйл

- Залруулга нийтэлснийг нэмэлт арга хэмжээ гэж тооцоогүй.
- 15 кейсийн заримд арга хэмжээ авсан гэж тэмдэглэсэн ч яг ямар үйлдэл хийснийг тодорхойлоогүй.
- Нэг кейст хэд хэдэн үйлдэл давхар байж болно.


Хэр хурдан залруулсан

бэ?

Анхны нийтлэл ба залруулгын яг огноо тогтоогдсон

73 кейс

Залруулга хүртэлх хугацаа (хоногийн бүлэг)



13

медиан хоног

20

90+ хоногийн дараах
залруулга

90+ хоногийн 20 кейсээс

- Шүүх: 14
- ХМЗ: 2
- Хэл ам / гомдол: 2
- Тодорхойгүй: 2

ХМБ алдаагаа сайн дураар залруулж буй тохиолдолд хомс байна.

Муу жишээ: залруулгын харагдах байдал

Хэзээ сүртэй уучлалт хүсдэг вэ?

№13

Залруулга: УИХ-ын гишүүн Ж.Золжаргалыг 52 орчим тэрбум төгрөг үр ашиггүй зарцуулсан талаар хотын дарга Х.Нямбаатарын хэлсэн үгийг редакцын үг мэт нийтэлсэн байна



Залруулга: Манай сайт 2025.08.22-ны өдөр хотын дарга Х.Нямбаатарын нийслэлчүүдэд хандан хийсэн мэдээллийг шууд дамжуулсан үзүүлсэн болно. Тус мэдээлэлд хотын дарга Х.Нямбаатар: "Тавантолгойн эрчим хүчний нүүрснээс шатахуун, хуванцар гаргах туршилтын үйлдвэрийн төсөлд 50 орчим тэрбум төгрөг зарцуулсан хэдий ч шороо овоолгоноос өөр ажил хийгээгүй. Тус төслийн гүйцэтгэгчээр "Паст Презент Солонхи" ХХК, түншлэгчээр "Кай минералс солонхи" ХХК ажилласан. "Кай минералс солонхи" ХХК-ийн захирал Ж.Азжаргал нь УИХ-ын гишүүн Ж.Золжаргалын дүү бөгөөд төсөл хэрэгжүүлэгч үед УИХ-ын гишүүн Ж.Золжаргал зөвлөх инженерээр ажилласан" гэж мэдээлсэн. Тус мэдээллээс урьдчилан бид 2025.08.28-ны өдөр "УИХ-ын гишүүн Ж.Золжаргал "Тавантолгойн эрчим хүчний нүүрснээс шатахуун, хуванцар гаргах туршилтын үйлдвэрийн төсөл"-ийн зөвхөн урьдчилгаа төлбөрт 1 тэрбум 740 сая төгрөг, нийт 52 орчим тэрбум төгрөгийг үр ашиггүй зарцуулжээ" гэж постер мэдээлэл бэлтгэн нийтэлсэн болно. Ингэхдээ ах сурвалж болох хотын дарга Х.Нямбаатар гэж тодотгох өгөөгүй нь санамсаргүй алдаа болсон талаар "Хэвлэл мэдээллийн зөвлөл"-ийн Ёс зүйн хорооноос зөвлөмж ирсэн тул залруулж байна.



№15

zarig.mn ЭХЛЭЛ УЛС ТӨР НИЙГЭМ ТА ЗАВТАЙ ЮУ ТӨСВИЙГ МӨШГӨӨ ОНЦЛОХ СУРВАЛЖ

TREND: "Г"Сайд нарын урсгал зардлаас 1,4 их наяд төгрөг танаж, төр бүсээ чанг...

Өнөөдөр:

ЗАЛРУУЛГА

ADMIN 2017/08/03

Зариг.мн вэб сайт нь 2017 оны наймдугаар сарын 01-ны өдөр "Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан 4 тэрбумын хадгаламжтай" гэсэн гарчигтай мэдээллийг нийтлэсэн билээ. Энэхүү мэдээллийг нийтлэхдээ нягталж шалгалгүй, хайхрамжгүй хандсаны улмаас алдаа гаргаж, их хэмжээний хадгаламжтай мэтээр ташаарч, олон нийтэд буруу ойлголт өгсөн алдаа гаргалаа.

Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн ХОМ-ээс жилийн орлого, хадгаламжийн хэмжээг мэдээлэхдээ цэцийн гишүүн Н.Жанцангийн хадгаламжийн хэмжээ 475019.68 төгрөг байсныг 4 тэрбум хэмээн бичиж, түүнийгээ нягталж, шалгалгүй нийтэлж, тухайн хүний нэр хүндэд халдсан байна. Тиймээс Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 1.9-т зааснаар "Нийтлэж, нэвтрүүлсэн мэдээлэл нь ташаа болох нь тогтоогдсон мэдээллийг нэн даруй залруулна" гэсний дагуу уншигч та бүхэнд залруулга хүргэж байна.

Ажилдаа хариуцлагагүй хандаж, бэлтгэсэн мэдээ мэдээллээ нягталж шалгаагүй сэтгүүлчид хариуцлага тооцсон болохыг үүгээр мэдэгдэж байна.

Мөн их хэмжээний хадгаламжтай мэтээр буруу мэдээлэл олон нийтэд хүргэсэн явдалдаа Үндсэн хуулийн Цэцийн гишүүн Н.Жанцангаас уучлалт хүсье.

Дахин нийм алдаа гаргахгүй гэдгээ уншигчиддаа амлаж байна.

Эргэлт-ийн нэр:	Навсантэрхий	Байгууллага:	Монгол Улсын Үндсэн хуулийн цэц
Нэр:	Жанцан	Албан тушаал:	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн

Мэдүүлэг гаргахтай тайлалт оны жигсаалт

Орон сууц барилга байгууламжийн тайлбар *

Орон сууцны хэсэгт: Орон сууц, дугуйн барилга, хувийн байшин, Ажлын орон сууц, Үйлдвэрлэл, үйлчилгээний хэсэгт: Үйлчилгээний зориулалттай, Үйлдвэрлэлийн зориулалттай, Оффисын барилга, Фэрм, Бусад хэсэгт: Газ, Авто зогсоол, Авто гараж, Фабрика, Гүний сүдэг, Хуурамч гэрлэлт...

Мэдүүлэг гаргах	Тайлбар	2015	2016	2017	2018	2019	2020	2021
	Албан тушаал	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн

№69

LIVETV WATCH

НҮҮР УЛС ТӨР ХУУЛЬ ЭРХЗҮЙ НИЙГЭМ СПОРТ БУСАД LIVE CONTENT

Залруулга

Нийгэм 2025/12/23 15:26 Д.Төв

"Ньюс инфо" компанийн livetv.mn сайтад 2025 оны зургаадугаар сарын 25-ны өдөр нийтлэгдсэн "УИХ-ын гишүүн Ж.Золжаргал Тавантолгойн эрчим хүчний нүүрснээс шатахуун, хуванцар гаргах туршилтын үйлдвэрийн төслийн зөвхөн урьдчилгаа төлбөрт 1 тэрбум 740 сая төгрөг, нийт 52 орчим тэрбум төгрөгийг үр ашиггүй зарцуулжээ" гэж мэдээллийг Хэвлэл мэдээллийн зөвлөл хянаад, "Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим"-ын 1.1, 1.2, 1.3 дахь заалтуудыг зөрчсөн хэмээн шийдвэрлэсэн байна.

Ёс зүйн хорооны хурлын шийдвэрийн талаарх хэвлэлийн мэдээг мэдээлж, ёс зүйн зарчмын зөрчлийг залруулахыг Ёс зүйн хорооноос зөвлөмж болгожээ.

Иймд УИХ-ын гишүүн Ж.Золжаргалын дээрх мэдээг залруулж байна.

Нийтлээг асуудал: стандарт бус бүтэц • залруулсан хэсэг тодорхой бус • эх мэдээтэй холбосон байдал /тайлбар сул

Муу жишээ

Залруулгын стандарт жигд бус!!!

№29

Залруулга



Админ | Zindaa.mn

🕒 2022 оны 08 сарын 29



Хуваалцах



Жиргэх

"Өглөөний сонин"-ы эх сурвалж бүхий "Ц.Даваасүрэн гишүүний "хайр" хөвсгөлчүүдээс халилаа" нэртэй нийтлэл 2021 оны 9 сарын 18-нд Zindaa.mn сайтад нийтлэгдсэн юм. Нийтлэлд зарим нэг ташаарсан зүйлс гарсан тул сонины зүгээс эрхэм гишүүнээс хүлцэл өчиж, залруулга гаргасныг хүргэж байна.



Хуваалцах



Жиргэх

№34

Залруулга



Д.Үржинбадам | Zindaa.mn

🕒 2017 оны 11 сарын 30



Хуваалцах



Жиргэх

Манай сайт нь 2017 оны 6 дугаар сард "Тусгаар тогтнолын хувьчлал 3,0 Ипотек хэмээх их бизнес" хэмээх нийтлэлийг бусад эх сурвалжаас авч өөрийн сайтад гаргахдаа мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлаагүй, редакцийн зүгээс анхаарч үзэлгүй нийтэлсний улмаас "Монголын Ипотекийн Корпораци ОССК" ХХК-ийн нэр хүндэд халдан, үйл ажиллагаанд нь сөрөг үр дагавар учруулахуйц, олон нийтэд төөрөгдөл өгөх, ташаа ойлголт төрүүлэх мэдээлэл түгээсэндээ хүлцэл өчиж, энэхүү залруулгыг гаргаж байна.

"МИК ОССК" ХХК нь 2006 онд байгуулагдсанаас хойш Монгол Улсын орон сууцны санхүүжилтийн зах зээлийн бүтцийг шинэ шатанд гаргах, олон улсын чиг хандлагатай уялдуулан өргөжүүлэх зорилготой ажилладаг байгууллага юм байна.

Иргэдийн орон сууцны зээлийн эрэлт хэрэгцээг хангах чиглэлээр МИК-ээс гаргасан үнэт цаас болох ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ) -ын үр шимээр нийт 90 гаруй мянга гаруй айл өрх зээлийн хүүгийн хөнгөлөлт эдэлж, шинээр орон сууцтай болж, ахуй амьдралаа сайжруулаад байгааг бид анзааралгүй олон нийтэд ташаа мэдээлэл хүргэжээ.

МИК-ийн үйл ажиллагаа бүхэлдээ орон сууцны санхүүжилтийн хоёрдогч зах зээл болох урт хугацааны үнэт цаасны зах зээлийн эхлэлийг тавьж, зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулах, бонд эзэмшигч нарын өмчлөлд буй үнэт цаасны төлбөрийг цаг хугацаанд нь найдвартай төлөх тогтолцооны тогтвортой байдлыг хангахад чиглэж ажиладагаараа онцлог бөгөөд энэ утгаараа тус байгууллагын үйл ажиллагааны онцлогийг бид мэдээгүйн улмаас үнэнд нийцээгүй нийтлэл түгээжээ.

Бидний зүгээс цаашид "МИК ОССК" ХХК-тай холбоотой мэдээ, мэдээлэл түгээхдээ эх сурвалжаа нягтлан бодит байдалд нийцсэн эсэхэд анхаарч ажиллана гэдгээ энэхүү залруулгаараа мэдэгдэж байна.



Хуваалцах



Жиргэх

Муу жишээ

Тодорхойгүй!!!

№24



UBn team

Огноо
2024-11-07 10:45:00

Унших
0 минут 43 секунд

Залруулга

Facebook

Twitter



Энэ сарын 5-ны өдөр манай сайтад МИАТ ТӨХК нь ажилчдын цалингаа тавьж чадахгүй дампуурлын байдалд орсон ч МАН-аас томилогдсон захирлууд нь нуусаар байна уу гэх мэдээлэл нийтлэгдсэн. Уг мэдээлэлд "Онгоцны үйлчлэгч охидыг шөнө оройн цагаар дуудаж бэлгийн дарамт учруулдаг, ирээгүй охидыг нь нислэгт гаргахгүй байх, цаашлаад зайлшгүй суух ёстой Авран хамгаалах сургалтанд нь явуулахгүй нэрийг нь хасах зэргээр дарамталдаг аж" гэх агуулга орсон нь мэдээллийг нягтлахгүйгээр нийтэлсэн тул залруулга гаргаж байна.

Муу жишээ: редакц руу дайрч орсон кейс

№37

Казах ахан дүүсээсээ хүлцэл өчье



Д.Үржинбадам | Zindaa.mn

🕒 2018 оны 03 сарын 14

Хуваалцах

Жиргэх

2018 оны 03 дугаар сарын 13-ны өдөр “Zindaa.mn” сайтад “Ц.Элбэгдоржийн цор ганц гавьяа”, “Монгол Казах хоёр хагарах учиргүй” нэртэй мэдээллүүд нийтлэгдсэн. Энэхүү мэдээллүүд нь түүхийг гуйвуулсан, Монгол Улсын үндэстэн ястны томоохон төлөөлөл болсон Казахстан ард түмнийг ёс зүйгүй байдлаар доромжилсон өнгө аястай, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйг илтэд зөрчсөн байх тул уг нийтлэлийг бичсэн сэтгүүлчийг ажлаас чөлөөлж, хариуцсан редакторт хариуцлага тооцсон болохыг мэдэгдэж байна.

Манай сайтын редакци нь Монгол Улсынхаа иргэн бүрийн мэдэх эрхийг хангаж, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйг дээдлэн ажиллахыг эрхэм болгодог. Гэвч тодорхой хувь сэтгүүлчийн зүгээс алдаа гаргаж ийм зүйл нийтэлсэнд Казахстан ахан дүүсээсээ гүнээ хүлцэл өчье.

Дашрамд дурдахад манай сайтад нийтлэгдсэн энэхүү мэдээ мэдээлэл нь ямар нэгэн захиалгат зүйл биш бөгөөд хувь сэтгүүлчийн өөрийн үзэл бодол, байр суурь байсныг мэдэгдэж байна. Бид цаашид энэ мэт алдаа гаргахгүй ажиллахад онцгой анхаарах болно.

"ZINDAA.MN" САЙТЫН ЗАХИРГАА, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Муу жишээ

Аймшигтай буруутгал, тэнцвэргүй залруулга: Ингээд л болоо юу?

№48



2018-01-21

МЭДЭЭ

Залруулга мэдээ

Хуваалцах:  


2017 оны дөрөвдүгээр сарын 03-ны өдөр Туг.мн сайтын онцлох мэдээ хэсэгт гарсан "Баянзүрх дүүргийн Засаг дарга Д.Пүрэвдаваагийн хууль бус үйлдлүүд" - гэсэн гарчигтай видео мэдээ нийтлэгдсэн билээ. Уг бичлэгт "Баянзүрх дүүргийн Засаг дарга Д.Пүрэвдавааг хамгаалах хүн цөөнгүй. Үймээн самуун гарах тоолонд гарч ирдэг хэсэг бүлэг хүмүүс ч бий. Тэдгээр хүмүүс Д.Пүрэвдаваагаас мөнгө, газар, албан тушаал авсан хороодын Засаг даргаас эхлэн албан тушаалтнууд түүний төлөө амь хайргүй зүтгэж байгаа нь энэхүү бичлэгээс харагдаж байна. 2012 оноос эхлэн тус дүүргийн Засаг даргаар ажиллахдаа Д.Пүрэвдаваа нь хууль бус үйлдэл, муу нэрээр олонд танигдах болж. Түүнийг анх таниулсан шуугиан бол хөл хүнд ажилтнаа зодож танхайрсан явдал байлаа. Түүний эрээ цээргүй явдлыг энэ бичлэгээр дамжуулан баримт нотолгоотой хүргэж байна"-гэсэн утгатай видео мэдээ нь хоёр талын тэнцвэрт байдлыг хангаагүй болохыг залруулж Д.Пүрэвдаваа таниас Туг.мн сайт уучлалт гуйж байна.

Хуваалцах:  

Муу жишээ

Мэргэжлийн бус залруулга!!!

№54



Энэ мэдээ хуучирсан буюу 2017/11/29-нд нийтлэгдсэн мэдээ болно.



[Шуурхай](#)

Ангилал

[Эдийн засаг](#)

Огноо

2017-11-29 03:06:20

Унших

2 минут 12 секунд

Facebook

Twitter

Залруулга

Манай сайт нь 2017 оны 6 дугаар сард “Тусгаар тогтнолын хувьчлал 3,0 Ипотек хэмээх их бизнес” хэмээх нийтлэлийг бусад эх сурвалжаас авч өөрийн сайтад гаргахдаа мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлаагүй, редакцийн зүгээс анхаарч үзэлгүй нийтэлсний улмаас “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-ийн нэр хүндэд халдан, үйл ажиллагаанд нь сөрөг үр дагавар учруулахуйц, олон нийтэд төөрөгдөл өгөх, ташаа ойлголт төрүүлэх мэдээлэл түгээсэндээ хүлцэл өчиж, энэхүү залруулгыг гаргаж байна.

“МИК ОССК” ХХК нь 2006 онд байгуулагдсанаас хойш Монгол Улсын орон сууцны санхүүжилтийн зах зээлийн бүтцийг шинэ шатанд гаргах, олон улсын чиг хандлагатай уялдуулан өргөжүүлэх зорилготой ажилладаг байгууллага юм байна.

Иргэдийн орон сууцны зээлийн эрэлт хэрэгцээг хангах чиглэлээр МИК-ээс гаргасан үнэт цаас болох ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ) -ын үр шимээр нийт 90 гаруй мянга гаруй айл өрх зээлийн хүүгийн хөнгөлөлт эдэлж, шинээр орон сууцтай болж, ахуй амьдралаа сайжруулаад байгааг бид анзааралгүй олон нийтэд ташаа мэдээлэл хүргэжээ.

МИК-ийн үйл ажиллагаа бүхэлдээ орон сууцны санхүүжилтийн хоёрдогч зах зээл болох урт хугацааны үнэт цаасны зах зээлийн эхлэлийг тавьж, зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулах, бонд эзэмшигч нарын өмчлөлд буй үнэт цаасны төлбөрийг цаг хугацаанд нь найдвартай төлөх тогтолцооны тогтвортой байдлыг хангахад чиглэж ажилаагаараа онцлог бөгөөд энэ утгаараа тус байгууллагын үйл ажиллагааны онцлогийг бид мэдээгүйн улмаас үнэнд нийцээгүй нийтлэл түгээжээ.

Бидний зүгээс цаашид “МИК ОССК” ХХК-тай холбоотой мэдээ, мэдээлэл түгээхдээ эх сурвалжаа нягтлан бодит байдалд нийцсэн эсэхэд анхаарч ажиллана гэдгээ энэхүү залруулгаараа мэдэгдэж байна.

Сайн жишээ

Нарийн тодорхой


№9

Монгол Улсын Ерөнхийлөгчийн найм дахь удаагийн сонгуулийн ирц болон санал хураалтын дүнг iKon.mn "Сонгууль-2021" хуудсаараа дамжуулан уншигчдад хүргэж байгаа билээ. Сонгуулийн Ерөнхий хороо нь сонгуулийн дүнг шууд нэгтгэж харуулахдаа онлайн орчинд байршуулдаггүй бөгөөд зөвхөн СЕХ-ны байр дахь тусгай дэлгэцээр шууд дамжуулан харуулдаг юм. Иймээс тус байгууллагаас дэлгэцээр үзүүлж байгаа тоон мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллагууд ямар нэг байдлаар бичиж дамжуулах хэрэгтэй болдог.

/Иймд алдаа гарах боломжтой тул СЕХ-ны шууд дамжуулалтын дэлгэцээс бусад хэвлэл мэдээллийн байгууллагын харуулж буй тоо мэдээг албан ёсны баримт болгон ашиглахгүй байхыг анхааруулж байна./

Энэ явцад Сонгуулийн Ерөнхий хорооноос танилцуулсан Багануур дүүргийн дүнгийн мэдээллийг алдаатай оруулсан тул уг мэдээллийг шуурхай залруулсан болно.

Зураг 1.



Түүнчлэн тус дүүргийн 22:00 цагийн байдлаарх ирцийн мэдээллийг оруулах хүртэл "Сонгууль-2021" хуудсан дээрх мэдээлэл 21:00 цагийн ирцээр харагдаж байсан болно.

Сайн жишээ

Тодорхой: Хэзээний мэдээ, ямар алдаа, хэн хохирсон, уучлалт, хариу арга хэмжээ

№26



Мэдээ ▾

Булан ▾

Улаанбаатар
☁️ -19°C

ЗАЛРУУЛГА



Өдрийн сонин
#Нийгэм · 2021-02-10 · 09:35



Dnn.mn сайт нь нийгэмд өрнөж буй үйл явдлаар ярилцлага, нийтлэл, сурвалжилга, тодруулга, мэдээ бэлтгэн нийтлэдэг билээ.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас арваннэгдүгээр сарын 24-ний өдөр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжид хяналт шалгалт хийсэн.

Ингэхдээ, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Үлэмж grosерс” ХХК-ийн “Good price” дэлгүүрт хяналт шалгалт хийхэд тус дэлгүүрт хонины ястай махыг 10500, үхрийн цул махыг 16000 төгрөгөөр худалдан борлуулж, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Улсын Ерөнхий байцаагчийн 110 тоот албан шаардлагыг биелүүлж ажиллаагүй, цар тахлын онцгой нөхцөл байдлын үед махны үнийн хөөрөгдөл үүсгэсэн нөхцөл байдал тогтоогдсон тул Зөрчлийн тухай хуулийн 10.7 дугаар зүйлийн 4.7 дахь хэсэгт заасан 20,000,000 төгрөгийн шийтгэл оногдуулсан” гэсэн албан мэдээг хүргэсэн юм.

Тус мэдээллийг 2020 оны арваннэгдүгээр сарын 25-ны өдөр сайтдаа мэдээлэхдээ "Хонины мах 16000 төгрөгөөр зарсан Good Price дэлгүүрийг 20 сая төгрөгөөр торгожээ" гэх гарчигтай мэдээллийг нийтэлсэн билээ.

Уг мэдээг хүргэхдээ үхрийн махны үнийг хонины махтай андуурсан зэрэг сэтгүүлчийн ур чадвараас шалтгаалсан баримтын алдаа гаргасан байна.

Иймд Dnn.mn сайтад нийтлэгдсэн "Хонины мах 16000 төгрөгөөр зарсан Good Price дэлгүүрийг 20 сая төгрөгөөр торгожээ" гэсэн мэдээнд дурдсан Үлэмж Grosерс ХХК-аас хүлцэл ирж, бэлтгэсэн мэдээгээ устгасан болохоо энэхүү залруулгаар илэрхийлж байна.

Dnn.mn сайтын редакши

Сайн жишээ

Шуурхай

№57



ЦХХХЯ-наас өнөөдөр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мэдээллийг ил болгосон. Уг мэдээлэлд орон нутгийн онцлогт тохирсон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх нэрээр "Алтай фүжи" компани 158 сая 800 мянган төгрөгийн зээл авсан ч 20,8 сая төгрөгийг нь төлөөгүй байна.

Манай сайт энэ талаар мэдээлэхдээ "Алтай фүжи" компанийн эцсийн өмчлөгч болох Түмэн-Өлзийгийн Мөнхбаярыг /2016-2020 онд Сүхбаатар дүүргийн ИТХ-ын төлөөлөгч/ Тогтохын Мөнхбаяртай /2020-2024 оны Сүхбаатар дүүргийн ИТХ-ын төлөөлөгч/ андуурч мэдээлсэн тул хүлцэл өчиж байна.

Tovch.mn сайтын редакц

Сайн жишээ

Хэн ч гомдоогүй үед, залруулах боломжгүй үед

№94

unnu.news

November 21, 2022 · 🌐

...

ЗАЛРУУЛГА: Катарын цагаачид ажил зуучлалын агентлагуудад 3000-4000 ам.долларын хөлс төлдөг.

Бид энэ дүнг 150,000-200,000 ам.доллар гэж бичиж баримтын алдаа гаргасандаа хүлцэл өчиж байна.

Энэ тоо нь цагаачдын зуучлалын хөлсийг Балбын рупи (NPR)-ээр илэрхийлсэн дүн юм.

2022 оны хөл бөмбөгийн ДАШТ-ийг хамгийн өндөр зардлаар буюу 220 тэрбум ам.долларын өртгөөр зохион байгуулж байна.

6.5 тэрбум хүн үздэг энэ наадамд зориулж Катар улс олон төрлийн зам, метроны нэгдсэн систем, 100 гаруй зочид буудал, 7 цэнгэлдэх хүрээлэн барьжээ.

Энэхүү асар том бүтээн байгуулалтыг тус улсын нийт иргэдийн 80 орчим хувийг эзэлдэг цагаачдын хөлсөөр босгожээ.

Катарт болж буй энэхүү хөдөлмөрийн мөлжлөгийг Guardian, BBC зэрэг томоохон хэвлэлүүд мэдээлж, хүний эрхийн байгууллагууд үүнийг зогсоох шаардлагыг хатуу тавьсаар ирсэн.

Тус улсын Засгийн газраас 2017 оноос хойш гадаадын ажилчдыг хэт халуунд ажиллахаас хамгаалах, тэдний ажлын цагийг хязгаарлах, ажилчдын хуаран дахь нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авч буйгаа зарлаж байгаа ч нөхцөл байдал одоог хүртэл сайжраагүй байна. See less

unnu

"FIFA World Cup Qatar 2022"

Хамгийн өндөр зардал, харгис хөдөлмөрийн мөлжлөг



Dua Lipa, Sir Rod Stewart нар Катарын ДАШТ-ний нээлтийн арга хэмжээнд дуулахгүй гэдгээ илэрхийлж, нэг сая ам.доллараас татгалзжээ.



Поп оддын татгалзсан шалтгаануудын нэг нь тус улсын цагаачдад үйлчилдэг кафала хэмээх харгис систем юм.

Кафала систем гэдэг нь: Ажлын өдөрнө мөнгөний түрэлтгэсгэн бөгөөд "наадам гэгдэгч" гэж өгчдөгдөг. Энэ систем нь цагаачдын ажилын мөнгөний түрэлтгэсгэн бөгөөд "наадам гэгдэгч" гэж өгчдөгдөг. Энэ систем нь цагаачдын ажилын мөнгөний түрэлтгэсгэн бөгөөд "наадам гэгдэгч" гэж өгчдөгдөг.

2019-2020 оны хооронд: 6.5 тэрбум ам.доллар зардалтай дуулахгүй гэдгээ илэрхийлж, нэг сая ам.доллараас татгалзжээ.

Катарийн хамгийн сая гаруй цочид буудал баригчид: Бельгидеги, Бельга, Кайд Селемге, Шиллениге, Дигедеге.

+5

DOMESTIC WORKERS ARE WORKERS TOO

INCLUDE US IN THE LABOR LAW

Зуучлагчийн эрх зөрчилгүйгээр ажиллах, эх орон руугаа буцах боломжгүй.

Хэрм цочигч хуураажаа гэгдэгчид нас бараал ор гаривсгэн нь гэгдэгч.

Энэ төрлийн ажилын мөнгөний түрэлтгэсгэн бөгөөд "наадам гэгдэгч" гэж өгчдөгдөг. Энэ систем нь цагаачдын ажилын мөнгөний түрэлтгэсгэн бөгөөд "наадам гэгдэгч" гэж өгчдөгдөг.

59

1

12

👍👎

№97

unnu.news

April 18, 2024 · 🌐

...

Зам гэж там болжээ.

Залруулга: Нийслэлийн хэмжээнд 700 мянга гаруй тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байдаг. See less

unnu.news



24 дүгээр зүйлийн 3, 4, 5-д заасны дагуу зарцуулна гэж заасан.

0:27 / 1:50

👍 31

💬 2

🔄 13

👍

Сайн жишээ

Залруулах боломжгүй үед, алдаагаа хүлээн зөвшөөрөх нь гарчгаасаа

№97



Долоо хоног тутмын "Unread Today" сонины 57-р дугаарт хэвлэгдсэн алдаатай мэдээлэлтэй холбоотой залруулга хүргүүлж байна.

<https://unread.today/c/newspaper-57> See less

UNREAD TODAY

СОНИНЫ 57 ДАХЬ ДУГААРЫН ЗАЛРУУЛГА

2025 оны есдүгээр сарын 29-нд түгээсэн, Unread Today сонины "Хадгалаад авъя! Хүү өсдөг сар эхэллээ" дугаарын А9-р нүүрт ташаа мэдээлэл нийтлэгдсэнийг уншигчдадаа мэдэгдэж байна.

Энэхүү нүүрэн дэх "Толомт банк энэ жил 30 жилийн ойгоо тохиолдуулан **есдүгээр сарыг** "Хадгаламжтай аялал" аяны хүү нэмэгддэг сар болгон зарлаж" гэсэн агуулга нь ташаа мэдээлэл бөгөөд үүний зөв нь "Толомт банк энэ жил 30 жилийн ойгоо тохиолдуулан **аравдугаар сарыг** "Хадгаламжтай аялал" аяны хүү нэмэгддэг сар болгон зарлаж" юм.

Төөрөгдүүлсэн мэдээлэл түгээсэнд хамтрагч байгууллага болон уншигч та бүхнээс хүлцэл өнчиж байна.

АДГАЛАМЖТАЙ АЯЛАЛ

ХҮҮ ӨСДӨГ САР ЭХЭЛЛЭЭ

30+
"30%-ийн нэмэлт урамшуулал"

11 1



№100

HumanZ редакц хэвлэл мэдээллийн ёс зүйн дүрмийг зөрчсөн мэдээлэл нийтэлсэндээ хүлцэл өчье

Үйлсдэллэг Мөнхбат | 2025 оны 10 сарын 10

UNCCD COP17 ULAANBAATAR 2025

Mongolia to Host COP17

Манай редакцын мэдээлэлд иргэн гомдол гаргасны дагуу Хэвлэл мэдээллийн зөвлөл дарвах шийдвэрийг гаргасан тул бид ёс зүйн дүрмийг зөрчсөн гэдгээ хүлээн зөвшөөрч, дарвах мэдээллийг нийтэлж байна.

[Шийдвэр хүргүүлэх тухай]

Танай сайтын албан ёсны социал хуудсанд 2025 оны наймдугаар сарын 21-ний өдөр нийтлэгдсэн "ТУЦ эрхлэгч 100 гаруй иргэнээс тус бүр 1 сая төгрөг авсан Х.Бат-Ялалт, Г.Одмаа нарын хэргийг шалгаж эхэллээ" гэх гарчиг бүхий мэдээлэлд иргэн Х.Б-с ирүүлсэн гомдлыг Ёс зүйн хорооны 2025 оны есдүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн үндсэн дээр танай редакцыг ёс зүйн алдаа гаргасан хэмээн шийдвэрлэсэн байна.

Хороо нь Хэвлэл мэдээллийн зөвлөлийн "Гомдол хүлээн авах, барагдуулах журам"-ын 6.3.2 болон 6.3.4-т заасны дагуу танай редакцын алдаагаа залруулах хүсэлтийг харгалзан үзэж" хэвлэл мэдээллийн байгууллага өөрийн гаргасан алдааг залруулсан буюу уучлал гуйсан тохиолдолд тухайн байгууллагын нэрийг зарлахгүй ба редакцад гомдлыг хэлэлцсэн дүгнэлтийг Хавсралтаар хүргүүлэх шийдвэр" гаргасан. Мөн Ёс зүйн хорооны хурлын шийдвэрийн талаарх хэвлэлийн мэдээг сайтаараа түгээх, алдаагаа албан ёсоор залруулж ХМЗ-д эргэн мэдэгдэхийг Ёс зүйн хорооноос зөвлөмж болгосныг үүгээр уламжилъя.

Ингэснээр хэвлэл мэдээллийн салбар, сэтгүүл зүйн бүтэцлийн агуулгад төрийн хяналт, зохицуулалт давамгайлхаас сэргийлэх, хэвлэл мэдээллийн байгууллага олон нийтийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлаж алдаагаа хуулийн шаардлагаар бус ёс зүйн өөрийн зохицуулалтаар залруулдаг эерэг соёлыг салбарт төдийгүй нийгэмд түгээхэд өндөр ач холбогдолтой билээ. Улмаар хэвлэл мэдээллийн редакц болон сэтгүүлчийг аливаа цензураас ангид алданаасаа сурвалч илүү мэргэших боломжийг өөрийн зохицуулалт олгодог тул Та бүхнийг алдаагаа залруулах, уучлал гуйх эерэг хариу үйлдлүүдийг үзүүлэх замаар ёс зүйт сэтгүүл зүйг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулна хэмээн итгэж байна.

Танграмд тэмдэглэхэд, танай редакцыг цэвэрлэн хүний нэр төртэй холбоотой аливаа мэдээллийг гэрээтэй

ХМЗ-ийн Ёс зүйн хорооны хэлэлцүүлэг ба редакцын хариу, 2015–2025

651

нийт хүлээн авсан гомдол


409

Ёс зүйн хороогоор хэлэлцсэн
62.8%

205

редакц хариу тайлбар
ирүүлсэн
50.1%

Хэлэлцсэн гомдлоос редакц хариу тайлбар ирүүлсэн хувь



2015: 56.2%

2016: 80.0%

2017: 18.3%

2018: 69.4%

2019: 39.4%

2020: 70.0%

2021: 60.0%

2022: 57.8%

2023: 31.6%

2024: 46.7%

2025: 50.0%

Тооцоолол: $409/651 = 62.8\%$; $205/409 = 50.1\%$. Жилийн хувь = редакцын хариу ÷ Ёс зүйн хороогоор хэлэлцсэн гомдол.

100 кейсээс харагдаж буй гол дүр зураг

1

Залруулга төвлөрсөн

100 кейс 42 хэвлэл/сайтад тархсан; zindaa.mn хамгийн олон буюу 9 кейстэй.

2

Эмзэг сэдэв давамгай

Гэмт хэрэг/осол + зөрчил нийлээд 65 кейс.

3

Баримт нягтлалт гол асуудал

Үнэн бодит байдлыг нягтлаагүй 59; нягт нямбай байдал алдагдсан 38 кейс.

4

Уучлалт олон нийтэд бус хохилогчдод

83 уучлалтаас ердөө 5 нь уншигч/олон нийтэд хандсан.

5

Corrective action ховор

Зөвхөн 15% нь залруулгаас гаднах хариу арга хэмжээний талаар дурдсан.

6

Удаашрал гаднын процессоор тайлбарлагдаж болзошгүй

Яг огноотой кейсүүдийн 20 нь 90+ хоног; тэдгээрийн 14 нь шүүхтэй холбоотой тэмдэглэлтэй.

Залруулгад тавигдах шаардлага: Яавал сайн залрах вэ?

1

Шуурхай: Алдаагаа мэдсэн даруйдаа

2

Цогц: хэвлэмэл, цахим, сошиал, ньюслэттер гэх мэт залруулж болох бүх сувгаар

3

Тодорхой: хэзээ нийтлэгдсэн, ямар гарчигтай, ямар агуулгатай, тэндээс аль хэсгийг залруулж буй, ямар алдааг хэн гаргасан, яагаад ийм алдаа гарсан, алдаа мадагаа хүлээн зөвшөөрч байгаа эсэх, хариу арга хэмжээ, цаашид яах юм г.м.

4

Алдаагаа хүлээн зөвшөөрөх: Хохирогчоос, хүлээн авагчдаасаа уучлалт хүссэн байх

5

Мэдээлэл VS Залруулга: ижил хэмд (алдааны хэмжээтэй дүйцэхүйц) (эх мэдээг засварлах, зассан тэмдэглээ оруулах, ньюслэттер)

6

Стандарт жигд- редакцын зохицуулалтад тусгагдсан байх

Суралцах нь:

«Нью-Йорк Таймс» сонин 112 жилийн өмнөх нийтлэлдээ залруулга хийлээ



Автор | Zindaa.mn

© 2011 оны 05 сарын 30

f Хуваалцах

Жиргэх

«Нью-Йорк Таймс» сонин 1899 оны нэгэн дугаартаа нийтэлсэн эмгэнэлд гаргасан алдаагаа залруулав. Талийгаачийн хамаатан болох 77 настай Дэниэл Швенкээс сонины редакци захидал авсны дараа залруулгыг гаргасан байна. АНУ-ын Нью-Гэмпшир муж улсын Уолпол хотын өндөр настан захидалдаа алдааг тодорхой зааж явуулахдаа тус сонины редакцийг залруулга гаргана гэж бодоогүй ажээ. Өндөр настан нэг сар орчмын өмнө илгээсэн захидалдаа, 112 жилийн өмнө нийтлэгдсэн, түүний үеэл өвөө, дэслэгч Мильтон К.Швенкийг нас нөгчсөний учир нийтэлсэн эмгэнэлд маш олон алдаа байсныг мэдээлжээ. Жишээ нь, эмгэнэлийн бичигт талийгаачийн нэрийг Мильтон бус Мельтон гэж бичсэн байна. Бас төрөл төрөгсдийг Пенсильвани муж улсынх гэхийн оргонд Жорж муж улсынх гэж бичсэний сацуу Мильтон Швенкийн АНУ-ын Тэнгисийн цэргийн академид сурч байсан оныг буруу заасан байжээ. Үеэл ач хүүгийн захидалтай танилцсан «Нью-Йорк Таймс» сонины сэтгүүлчид сониндоо гарсан эмгэнэлийг шалгаж, дараа нь түүхийн болон генийн мэргэжилтнүүдийг оролцуулан мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн байна. Эцэст нь 1899 онд мухар олгойн үрэвлийн улмаас Нью-Йоркт нас барсан дэслэгчийн тухай үнэн зөв мэдээллийг нийтэлжээ. Дэниэл Швенк сонины хамт олонд талархал илэрхийлээд, сэтгүүлчдийн хийсэн ажил түүнийг АНУ-ын янз бүрийн хотод аж төрж байгаа төрөл төрөгсдөө хайх ажилд урам зориг өгснийг тэмдэглэсэн байна.

Эх сурвалж: Монцамэ

Corrections

The Times recognizes an ethical responsibility to promptly correct all factual errors, large and small. We encourage you to contact us if you think you see a mistake. Messages about news coverage can be sent to corrections@nytimes.com; comments about the Opinion section should go to letters@nytimes.com.

Learn more about how we handle corrections [here](#). For other questions, including subscription issues, visit our [help center](#).

Залруулгыг кодоод тусгах нь: Редакцын зохицуулалт

маш чухал

1. SPJ Code of Ethics — АНУ

Хариуцлагатай, ил тод байх зарчмын дор алдааг хүлээн зөвшөөрч, шуурхай бөгөөд ил харагдахуйц байдлаар залруулах, залруулгыг ойлгомжтой тайлбарлахыг шаарддаг.

2. IPSO Editors' Code — Их Британи

Ноцтой ташаа мэдээлэл, төөрөгдүүлсэн мэдэгдэл, гуйвуулгыг шуурхай бөгөөд зохих хэмжээнд харагдахуйц байдлаар залруулах, шаардлагатай тохиолдолд тусдаа уучлалт нийтлэх ёстой гэж заасан.

Алдааны хэмжээ, харагдацтай дүйцэхүйц зохистой байдлаар залруулна.

3. Associated Press (AP)

Алдаа гарсан бол бүрэн, хурдан, ил тод, дурамжхан бус байдлаар засах зарчимтай.

ЗАЛРУУЛГА

- Хүндлэл · Эргэх холбоо
- Ил тод байдал · Үнэн зөв байдал
- Засах, сайжрах · Хариуцлага хүлээх
 - Итгэл сэргээх
- Мэргэжлийн стандарт · Итгэлцэл

Анхаарал хандуулсанд баярлалаа.
iderjargal@num.edu.mn